



ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: info@pcsp.gov.mn,
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2020.07.27 № А-1/1307
танай _____-ны № _____-т

Чиглэл хүргүүлэх, шийдвэр
хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 10 дугаар тогтоолын 4 дэх заалтад үнэлгээнд хамрагдаагүй газар эзэмших, ашиглах эрх, дахин үнэлгээ хийгдээгүй үл хөдлөх хөрөнгийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлалын дагуу үнэлж, 2020 оны санхүүгийн тайланд тусгах ажлыг зохион байгуулахыг Сангийн сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан билээ.

Сангийн сайдын 2020 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 7/4446 дугаар албан бичигт газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээнд Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн "Аргачлал батлах тухай" 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалыг ашиглах чиглэл ирүүлсэн байна.

Иймд Засгийн газрын шийдвэрээр 2018 онд хийгдсэн дахин үнэлгээний ажлын явцад дахин үнэлгээ хийгдээгүй үл хөдлөх хөрөнгө, үнэлгээ хийгдээгүй орхисон газар эзэмших, ашиглах эрх, мөн 2018 оноос 2020 онд шинээр олж авсан газар эзэмших, ашиглах эрхийг дээр дурдсан аргачлалын дагуу нөхөн үнэлж, нягтлан шалгалтын үнэлгээчнээр баталгаажуулан, дүнг 2020 оны санхүүгийн тайланд тусгах нь зүйтэй.

Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолыг хэрэгжилтийг ханган, биелэлтийг 2020 онд багтаан ирүүлэхийг мэдэгдье.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ